

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ



**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ  
ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ЗҮЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулийг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж хуульчлан төрийн үйл ажиллагааны нийтээр дагаж мөрдөх суурь зарчим болон авлигаас ангид байх төрийн бодлогын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнчлэн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “иргэн нь хөдлөх, үл хөдлөх **хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжуулах эрхтэй.**” гэж хуульчлан иргэн өмчийн эрхээ шударгаар хэрэгжүүлэх суурь зарчмыг мөн тунхаглан баталгаажуулсан байна.

Түүнчлэн, Монгол Улс а)авилгалын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгаад сэтгэл зовнож; б)эд **баялгийг хувьдаа хууль бусаар олж авах нь** ардчилсан тогтолцоо, үндэсний эдийн засаг, хууль дээдлэх ёсонд нэн хохиролтой гэдэгт итгэж; с)эд **хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхэд** эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний буюу захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудыг баримтлахыг хүлээн зөвшөөрч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан “Авлигалийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-д 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан байна.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.”-оор хуульчилсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгаснаар “...хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” хэмээх зорилгыг тодорхойлж, улмаар тус зорилгыг хэрэгжүүлэхээр “Авлигагүй засаглал” буюу “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээх зорилтуудыг дэвшүүлжээ.

Түүнчлэн тус зорилтуудыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бурдэнэ.” гэж, “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэрэг буурсан байна.” хэмээх үр дүнд хүрэхээр тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрөөр улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх, хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулах, авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулах зэрэг чухал зорилгуудыг дэвшүүлсэн байна.

Тус “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилго 6-д “Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, Зорилт 6.1-д “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана.” гэж, 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.1.5-д “Авлигын гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцуулж тодорхойлно.” гэж, 6.1.10-т “Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлнэ.” гэж, 6.2.5-д “Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцуулнэ.” гэж, 6.3.1-д “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.3.2-т “Оффшор бус, гадаад улсаас шилжүүлэн авсан хууль бус хөрөнгө, орлого, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх явцад хураасан хөрөнгийг нээлттэй, ил тод байдлаар зарцуулах тогтолцоог бий болгоно.” гэж, 6.3.3-т “Нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө буцаах болон захиран зарцуулах нөхцөл, журам, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 6.4.2-т “Авлигын гэмт хэрэгт үгсэн тохиролцож, хууль бусаар давуу байдал олж авсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгоно.” гэж, 7.5.2-т “Төрийн аудитын тухайн жилийн сэдвийн төлөвлөлт, аудитын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж, эргэх холбоо тогтоох нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 7.5.3-т “Засгийн газрын хяналт шалгалт, төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгоно.” гэх зэргээр авлигагүй нийгмийг бий болгоход чиглэсэн, ач холбогдол бүхий томоохон бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан гол зорилт болох Зорилт 16-д “санхүүгийн ... хууль бус урсгалыг мэдэгдэхүйц бууруулах, хулгайлалттай гэмт хэрэгтэй тэмцэх” гэж мөн онцлон тодотгон тусгасныг нэмж дурдах нь зүйтэй.

Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 32-т авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид үнэлгээ хийж, боловсронгуй болгоход чиглэгдсэн ажил, арга хэмжээ, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Хууль бус хөрөнгийг хураах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах” гэж заасан байна.

## 1.2.Практик үндэслэл, шаардлага

1.Монгол Улсад авлигын эсрэг чиглэсэн дараах гол хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.Үүнд:

- Авлигын эсрэг хууль (2006 он);
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он);
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013 он);
- Эрүүгийн хууль(2015 он);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль(2017 он).

Эдгээр хуулиуд нь авлигатай тэмцэх гол арга хэрэгсэл болох боловч бодит үр дүн гаргах тал дээр хүндрэлтэй байгааг олон улсын судалгаанууд илэрхийлдэг. Тухайлбал, Монгол Улс “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас гаргасан Авлигын төсөөллийн индексээр манай улс 180 улсаас 2018 онд 93, 2019 онд 106, 2020 онд 111, 2021 онд 110-т эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 6 байраар ухарч 116-д, 2023 онд өмнөхөө оны эрэмбээс 5 байраар ухарч 121-д эрэмбэлэгдсэн байна.

Энэхүү авлигын төсөөллийн индекс нь манай улсын авлигын тувшинд өгч буй олон улсын байгууллагын үнэлгээ бөгөөд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлэх нь тус үнэлгээнд ахиц гаражад нэг алхам болно гэж үзэж байна.

2.Авлигын гэмт хэрэг шийдвэрлэлтийн байдлыг 2017-2023 оны тоон мэдээллээс харуулбал:

Авлигатай тэмцэх газраас 2017-2023 онуудад нийт **8860** авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас **1578** хэргийг шүүхэд шилжүүлэх

саналтайгаар, **2988** хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай шийдвэрлэж байсан байна<sup>1</sup>.

2017-2023 онуудад Прокурорын байгууллагаас нийт **7229** авлигын гэмт хэрэгт хяналт тавьж ажилласнаас **1005** хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, **121** хэргийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгожээ.<sup>2</sup>

Прокурорын байгууллагаас шүүхэд 2017-2023 онуудад шилжүүлсэн 1005 хэргээс шүүх нийт **739** хэргийг нь шийдвэрлэж, 20 хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн хэрэг нь хянан шийдвэрлэх шатанд байна.<sup>3</sup>

Эндээс үзвэл улсын хэмжээнд 2017-2023 онуудад мөрдөн шалгах ажиллагаа хийгдсэн **8860** авлигын гэмт хэргийн **739** нь буюу **8,3 хувь** нь л шүүхээр шийдвэрлэгдэж, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд нийт **3129** хэрэг нь буюу **35 орчим хувь** нь хэрэгсэхгүй болж шийдвэрлэгджээ.

Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч, улсын орлого болгосон эсэхэд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд 2018-2023 онуудад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан авлигын хэргийн гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирлын хэмжээ **1.5 их наяд төгрөг**, битүүмжилсэн хөрөнгийн үнийн дүн **865.4 тэрбум төгрөг**<sup>4</sup> байсан ба Прокурорын байгууллагаас эдгээр онуудад нийт **14.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгө орлого хураан авсан байна**.<sup>5</sup>

Гэтэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн 2018-2023 онуудад шүүхээс хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн тоон мэдээллээс үзвэл **авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хураан авсан талаар тоон мэдээлэл** гараагүй.

Түүнчлэн 2013-2017 онд Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн нийт учирсан хохирлын хэмжээ 299,8 тэрбум төгрөг байснаас 20.3 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Мөн эдгээр онуудад Авлигатай тэмцэх газраас 85.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээллээс үзвэл 2013-2017 онуудад гэмт хэрэг үйлдэж олсон **400 сая төгрөгийн хөрөнгө, орлогыг хураан авсан байна**. Энэ нь эдгээр онуудад гарсан албан тушаалын гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын **0.1 хувьтай**, битүүмжилсэн хөрөнгийн **0.4 хувьтай** л тэнцэж байна.

Хууль бус буюу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдэж эхэлсэн Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад

<sup>1</sup> Авлигатай тэмцэх газар, Статистик эмхэтгэл (2007-2023 он), 2024 он

<sup>2</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын 2024 оны 9 дүгээр сарын 20-ны 1/6619 тоот албан бичиг

<sup>3</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 24-ны 01/1493 тоот албан бичиг

<sup>4</sup> Авлигатай тэмцэх газар, Статистик эмхэтгэл (2007-2023 он), 2024 он

<sup>5</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын 2024 оны 9 лугээр сарын 20-ны 1/6619 тоот албан бичиг

шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно" гэж тусгаснаас гадна, 7.5 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг зөвхөн тодорхойлох байдлаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг заавал хураах, нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.

Харин 2002 онд батлагдан мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эд хөрөнгө хураах ял оногдуулсан эсэхээс үл хамааран заавал хураах зохицуулалттай байжээ.

3. Авлигын эсрэг хуульд заасан, нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх процесс, үүнээс гадна хураасан хөрөнгө, орлогыг эрхлэн удирдах, эрхлэн удирдсанаас олсон орлогыг зарцуулах, тайлагнах эрх зүйн орчин тодорхой бус, түүнчлэн авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах талаар хуулийн зохицуулалтгүй байна.

Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д "үндэслэлгүйгээр хөрөнгөжих"-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд "үндэслэлгүйгээр хөрөнгөжих" гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт "Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох." -оор тус тус хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байна.

Авлигатай тэмцэх гол арга замын нэг нь авлигын улмаас бий болсон хөрөнгийг буцаах буюу хураан авах, нөхөн төлүүлэх бодлого юм. Ялангуяа эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдалд хүргэсэн хуульд заасан үндэслэл бий болсон эсэхийг үл харгалзан гэм буруутай эсэхийг тогтоох, ял шийтгэл ногдуулах асуудлыг хөндөлгүйгээр зөвхөн гэмт хэргийн улмаас олсон буюу хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх механизм буюу эрх зүйн тодорхой зохицуулалт чухал шаардлагатай юм.

Иймд нийтийн албан тушаалтны гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого болон хууль ёсны орлогоос давсан, хууль ёсны болохыг тайлбарлаж чадаагүй хөрөнгө, орлогыг заавал хураан авах, нөхөн төлүүлэх процессын зохицуулалтыг тодорхой болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна. Улмаар авлигатай тэмцэх зорилгоор авлигын мэдээлэгчээс мэдээлэл авах, авлигын мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах эрх зүйн зохицуулалтыг нэн яаралтай бий болгох нь зүйтэй байна.

4. Сүүлийн жилүүдэд эрх бүхий байгууллагад бүртгэгдэж, шүүхээс таслан шийдвэрлэгдсэн авлигын, ялангуяа нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэргүүдээс үзэхэд, гэмт этгээд бусдаас тэрбум, түүнээс дээш хэмжээний хахууль авсан болох нь тогтоогдож, иргэдийг ихээр бухимдуулж байна. Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан их хэмжээний хахууль буюу нэг зуун сая төгрөгөөс дээш хэмжээний хахууль авсан бол тухайн этгээдэд Эрүүгийн хуулийн 22.4

дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа бөгөөд тодруулбал, нэг зуун сая төгрөгийн хахууль авсан, нэг зуун тэрбум төгрөгийн хахууль авсан этгээдийн үйлдэлд Эрүүгийн хуулийн адил зүйл, хэсгээр зүйлчилж, адил ял оногдуулж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй бөгөөд “онц их хэмжээний” буюу тэрбум түүнээс дээш хэмжээний хахууль авсан нийтийн албан тушаалтны үйлдлийг хүндрүүлэн зүйлчилж, хүлээлгэх ялыг чангатгах шаардлагатай байна.

Түүнчлэн тус гэмт хэргийн шинжийг “Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол ..” гэж Эрүүгийн хуульд тодорхойлсон нь нийтийн албан тушаалтан хээл хахуулийг өөртөө авалгүйгээр “төлөөний хүн”-д хээл хахуулийг өгүүлсэн үйлдэл нь тус гэмт хэргийн шинжид хамаarahгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тус гэмт хэргийг үйлдэгч нарт ял оноох, хариуцлага ногдуулах боломжгүй хийдэлтэй зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийн гаралт, хахуулийн хэмжээ, гэмт этгээд энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдэх байдал нэмэгдэх хандлагатай байна.

Иймд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан, энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хахууль авсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх мөн шаардлагатай байна.

5.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг хэлбэрийн шинжтэйгээр /хохирлын хэмжээ шаардахгүй/ хуульчилсан нь хохирол их, багаас үл хамааран адилхан ял шийтгэл хүлээхээр байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан шударга ёсны зарчимтай мөн нийцэхгүй байна.

6.Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэрэг нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг хэдий ч энэ гэмт хэргийн субъектив талын шинжид гэм буруугийн хэлбэрийг тодорхой зааж өгөөгүйн улмаас практикт хайнга хандах гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (22.1) гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна. Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлд албан тушаалын гэмт хэрэгт бүлэгт хуульчилж байсан уламжлал, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд хайнга хандах гэмт хэргийг авлига, албан тушаалын гэмт хэргийн бүлэгт хуульчилсан туршлага, энэ төрлийн гэмт хэргийн онцлог, нийтийн албан тушаалтан ихэвчлэн үйлддэг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хуульчлах шаардлагатай байна.

Мөн практикт Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учирдаг. Тус гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж, авлигын гэмт хэрэг үйлдсэн нийтийн албан тушаалтан хөнгөн ял шийтгэгдэх, улмаар нийтийн албанд ажиллах, хууль тогтоох дээд байгууллагын сонгуульд нэр дэвших боломжийг бүрдүүлсэн хийдлийг засах шаардлагатай болжээ.

7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдлийн үнэлгээгээр<sup>6</sup> манай улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох эрсдэлтэй гэмт хэргийг үнэлсэн бөгөөд уг үнэлгээгээр 1.авлигын, залиах, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүд өндөр эрсдэлтэй, 2.татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд дунд эрсдэлтэй, 3.хөрөнгө завших, хулгайлах, мал хулгайлах гэмт хэргүүд бага-дунд эрсдэлтэй, 4.улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд бага эрсдэлтэй гэж дүгнэжээ.

Гэвч мөнгө угаах гэмт хэргийг сүүлийн 4 жил эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 193 хүнд холбогдох 172 хэргийг шийдвэрлэжээ.<sup>7</sup> Нийт суурь гэмт хэргээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 154 буюу 90.5 хувийг, эдийн засгийн гэмт хэрэг 2 буюу 1 хувийг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг, авлигын гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 2.3 хувийг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн дийлэнх хувийг өмчлөх эрхийн эсрэг(хулгайлах, мал хулгайлах, залиах, дээрэмдэх) гэмт хэрэг эзэлж байна.

Мөнгө угаах гэмт хэргээр нийт 193 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнээс бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаасан хүн 160 буюу 83 хувийг, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаасан хүн 33 буюу 17 хувийг тус тус эзэлж байгаа судалгаа байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт бүх гэмт хэргийг хамаарахаар хуульчилсан атал зөвхөн дээр дурдсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн хүрээнд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлэх практик тогтсон гэж үзэж болохоор байна.

Иймд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг олон улсын гэрээ, конвенц, ФАТФ-ын зөвлөмж, суурь гэмт хэргийг тодорхойлох олон улсын аргачлалыг харгалзан оновчтой тодорхойлох, бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаах, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаах үйлдлийг ялгамжтай байдлаар хуульчлах, энэ гэмт хэргийг виртуал хөрөнгө ашиглаж, хуулийн этгээдийг халхавчаар ашиглаж, үндэстэн дамнаж

<sup>6</sup> Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдлийн үнэлгээ. Уб., 2020

<sup>7</sup> Б.Батцэрэн. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, ял оногдуулах асуудал. Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2024. 43 дахь тал

үйлдсэн бол нийгмийн аюулын шинжийг харгалзан хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилах шаардлагатай байна.

8. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д “Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.” гэж заасан.

Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээд нөлөөлөх байдлыг таслан зогсоох зорилгоор Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.16 дугаар зүйлд шүүгч хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй, эсхүл бүрэн бус, худал хөтлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцох замаар, мөн шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх (Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл) гэмт хэргийн объектив талын шинжид эдгээр албан тушаалтанд бусад байдлаар нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн үйлдлийг нэмж, тус зүйлийн хууль тогтоогчийн тайлбарт заасан улс төрд нөлөө бүхий этгээдэд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа болох өмнө нь ажиллаж байсан хүнийг ойлгохоор хүрээг өргөжүүлэн нэг талаас шүүгчийг нөлөөллөөс хамгаалах, нөгөө талаас дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх хөшүүрэг бий болгох шаардлагатай байна.

9. Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүй Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг хяналтаас гарах эрсдэлтэй гэж үзэж байна. Иймд авлигын гэмт хэрэгт, тодруулбал цагдаагийн байгууллага өөрсдөө илтрүүлсэн, эсхүл орон нутагт гарсан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүчин чадлыг ашиглан явулахаар хуульчлах нь зүйтэй гэж үзлээ.

10. Төрийн аудитын байгууллагаас 2020-2023 онд гүйцэтгэсэн аудитын явцад гэмт хэргийн шинжктэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул прокурорын байгууллагад мэдэгдэж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар нийт 3.6 тэрбум гаруй төгрөгийн зөрчил бүхий 67 асуудлыг шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлэн хүргүүлсэн нь бүгд төсвийг хууль бусаар зарцуулсан зөрчлууд байсан гэжээ.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар прокурорын байгууллага төрийн аудитын байгууллагаас 2020-2023 онуудад нийт 45 мэдээлэл ирүүлснийг цагдаагийн байгууллагад 1, Авлигатай тэмцэх газарт 44 асуудлыг шалгуулахаар хүргүүлсэн байна.

Эдгээрээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан нийт 24, хэрэг бүртгэл нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа 13, мөрдөн байцаалт явуулсан 8, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн 5 хэрэг байна.

Түүнчлэн Төрийн аудитын тухай хуульд төрийн аудитын байгууллагын тогтоосон хүчин төгөлдөр төлбөрийн акт, албан шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ гэж заасан ч нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг байна.

Иймд хүчин төгөлдөр болсон төлбөрийн актыг шүүхээр баталгаажуулж албадан гүйцэтгэх хуулийн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Мөн бусад хуульд Төрийн аудитын тухай хуульд зааснаас өөрөөр зааж зарим байгууллага төрийн аудитад хамрагдахгүй үлдэх боломжийг олгосон байдаг. Жишээлбэл, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аudit хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ.” гэж заажээ.

Иймд төрөөс санхүүжсэн, татаас, зээл авсан буюу төсвийн мөнгөн хөрөнгөнөөс ямар нэг байдлаар хувь хүртсэн хувийн эрх зүйн хуулийн этгээд, иргэний хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт аudit заавал хийх асуудлыг тодорхой болгож хуульчлах шаардлагатай байна. Улмаар төрийн аудитын, ялангуяа аудитын дээд байгууллагын удирдлагын хараат бус байдлыг бэхжүүлсэн, аудитын бүрэн эрхийг нь тодорхой хуульчилж баталгаажуулсан эрх зүйн сайн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгох нь даамжирч, иргэдийн боломжийг хязгаарлан, эдийн засаг, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүхий л салбарт тэгш бус байдлыг үүсгээд байна. Энэ нь улс орны эрсдэлийг нэмэгдүүлэн олон улсын байгууллагуудын үнэлгээнд муугаар нөлөөлж, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулахад хүргэж байна.

Авлигатай тэмцэх, төсвийн хөрөнгийг хамгаалах, төрийн албыг шударгаар хэрэгжүүлж шударга, ил тод байдлыг хангахад төрийн аудитын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн аудитын байгууллага төсвийн зарцуулалт, хуваарилалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомжийн дагуу зүй ёсоор явагдаж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Төрийн аudit нь төрийн байгууллагыг төсвийн хөрөнгийг үр ашиггүй ашиглах, зарцуулах, завших, үрэгдүүлэх байдал, авлигын эрсдэлийг илрүүлэх зэргээр авлигаас урьдчилан сэргийлэхэд бодитой хувь нэмэр оруулдаг нэг арга хэрэгсэл байдаг.

Дээр дурдсан байдлаас дүгнэвэл авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй байдал, нийтийн албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон болон хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авах, хураан авсан хөрөнгө, орлогыг хадгалах, захиран зарцуулах, захиран зарцуулснаас олсон орлогын үр дүнтэй зарцуулалт, түүнд хяналт тавих, төрийн албан хаагчийн хууль бус ажиллагааны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин, тогтолцоог хангалттай бурдүүлээгүй, авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах хууль тогтоомжгүй байгаа нь цаашид авлигын гэмт хэргийг улам даамжуулах эрсдэлтэй гэж үзэхээр байна.

Иймд авлигын эсрэг арга хэмжээг илүү үр дүнтэй болгохын тулд эрх зүйн орчин, хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалт зэрэг бүхий л түвшинд шинэчлэл хийх шаардлагатай байна. Энэ нь эрх зүйн орчны чанга бодлого төдийгүй төр засаг, олон нийтийн итгэлцэл, эдийн засгийн хөгжлийг дэмжих суурь алхам болох нь тодорхой юм.

Иргэд нь бага, дунд орлоготой улс орны хувьд авлига нь хөгжлийн асар том саад болдог бөгөөд иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг супруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлэх, төрөөс иргэдэд хүргэх эрүүл мэнд, боловсрол гэх мэт үйлчилгээ, иргэдийг хангалттай орлоготой болгох арга хэмжээ, бизнесийг зохистойгоор явуулах механизмд хор хөнөөл учруулах зэрэг олон талын хохирлыг тухайн улс оронд учруулдаг.

Авлигыг бууруулах, авлигагүй төртэй болох зорилго, зорилтыг хангахад нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг буцаах буюу хураан авах, нөхөн төлүүлэх арга хэмжээ чухал бөгөөд тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд оновчтой стратеги боловсруулан хэрэгжүүлж хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхэд хэрэглэх эрх зүйн арга зам, хэлбэрүүдийг сайтар тооцоолж, оновчтой хувилбарыг сонгох нь нэн тэргүүнд тавигдах асуудал болоод байна.

Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг явуулахад хэрэглэх эрх зүйн арга хэрэгсэл нь стратегийн ач холбогдолтой нөлөө үзүүлж, гэмт хэрэг, зөрчлийн үр дагаварт чухал үүрэг гүйцэтгэдэг ач холбогдолтой.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн шударга ёсыг хангах, нийтийн албан тушаалтны гэмт хэргийг бууруулах, төсвийн хөрөнгө болон төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хураан авсан хөрөнгийг үр ашигтай эрхлэн удирдаж нийгмийн сайн сайхны төлөө зарцуулах зорилгоор Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай нэртэй анхдагч хуулийн төслөөс гадна дагалдах бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.4-т “Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.” гэж, 14.5-т “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.” гэж тус тус заасны дагуу багцлан боловсруулна.

**Хоёр.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа**

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, зохицуулах харилцаа, албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт;

2/хоёрдугаар бүлэгт албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх зарчим;

3/гуравдугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалгах, иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх ажиллагааны оролцогч буюу хууль бус хөрөнгө шалгах, иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, холбогдогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрчийн эрх, үүрэг;

4/дөрөвдүгээр бүлэгт хууль бус хөрөнгө шалгах, иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах тухай;

5/тавдугаар бүлэгт нотлох баримтын тухай;

6/зургадугаар бүлэгт хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа, түүнийг явуулах үндэслэл, шалгах ажиллагааны хамрах хугацаа, шалгах ажиллагаа явуулах журам, шалгах ажиллагаа явуулах тодорхой төрлийн ажиллагаа, хууль бус хөрөнгийг битүүмжлэх, түр хураан авах, шалгах ажиллагааны баримт бичиг, прокурорын зөвшөөрөл, шалгах ажиллагаа явуулах хугацаа, нууцлал, нийтэд мэдээлэх, хөрөнгө шалгах ажиллагааны шийдвэр гаргах тухай;

7/долдугаар бүлэгт хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тухай;

8/наймдугаар бүлэгт хөрөнгө шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын тухай ;

9/есдүгээр бүлэгт хууль бус хөрөнгийг гаргуулах, нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай;

10/аравдугаар бүлэгт олон улсын хамтын ажиллагааны тухай;

11/арван нэгдүгээр бүлэгт бусад зохицуулалт буюу мэдээллийн сан, тайлангийн тухай.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт нь нийгмийн шударга ёсыг хангахад онцгой чухал үүрэгтэй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар авлигын эсрэг хууль тогтоомж боловсронгуй, тодорхой болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр нөлөө үүсгэнэ гэж үзэж байна. Үүнд:

1.Нийтийн албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, шударга ёсыг хангах, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, сэргээх, хууль бус үйлдлийг үл хүлээн зөвшөөрөх, үл тэвчих ёс зүй, соёлыг нийгэмд бий болгох, төрийн байгууллагын хариуцлагатай байдал дээшлэхэд чухал ач холбогдолтой.

2.Хуулийн төсөл батлагдсанаар авлигын гэмт хэргийн гаралт буурах, авлигатай тэмцэх төрийн бодлого чангач, хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, хохирол нөхөн төлүүлэх байдал сайжирч, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчим баталгаажна гэж үзэж байна.

3.Төрийн албыг шударга, зөв, зүй зохистой, үр дүнтэй, ёс зүйтэй, хууль ёсны байлгахад үндэс суурь болох буюу хууль бус аргаар хөрөнгөждөг байдал арилахад томоохон эерэг нөлөө үзүүлнэ.

4.Хууль бус хөрөнгийг хураан авч улсын орлого болгосноор төрөөс авч хэрэгжүүлж буй хөгжлийн болон нийгмийн хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

5.Авлигын эсрэг тус бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд олон улсын холбогдох индекс, үзүүлэлт өсөхөд хувь нэмэр болно.

6.Нийтийн албан тушаалтнуудын хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааг тодорхой болгоно.

7.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан "Авлигагүй төр болох" гол зорилтоо хангахад гол түлхэц болно.

8.Нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг иргэний журмаар нэхэмжлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ба ингэснээр шудрага эзэмшигчийн эрхийг хөндөхгүйгээр хураах, битүүмжлэх, гэмт хэрэг шүүхээс шийдвэрлэгдэхээс өмнөх шатанд битүүмжлэгдэж, хураагдсан хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд хэрхэн хадгалж, хамгаалах, хөрөнгө, орлогыг хураах тухай шүүхийн шийдвэр гарсны дараа хөрөнгийг (шүүхийн шийдвэрээр шинээр хураасан хөрөнгө, орлого мөн хамаарна) тухайн хөрөнгө, орлогын шинж чанаараад хэрхэн эрхлэн удирдах, захиран зарцуулах хэлбэрүүд, худалдах тохиолдолд дуудлага худалдаа явуулах, худалдах, түрээсэлснээс олсон орлогыг мэдээлэх, эдгээр үйл ажиллагаанд хяналт тавих, тайлاغнах, ил тод болгох зохицуулалт, эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо зэрэг олон асуудал тодорхой болно.

9.Нийтийн албан тушаалтан хээл хахууль авах гэмт хэрэгтээ "төлөөний хүн" оролцуулсан буюу хээл хахуулийг "төлөөний хүн"-д өгүүлсэн(өөрөө аваагүй) үйлдлийг авлигын гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгаснаар одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хууль дахь хээл хахууль авах гэмт хэргийн шинж хийдэлгүй, оновчтой тодорхойлогдоно.

10.Нийтийн албан тушаалтны "төлөөний хүн" авлигын гэмт хэргийн улмаас "үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн" үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болсноор нийтийн албан тушаалтны авлигын гэмт хэрэгт тусладаг, хамтран оролцдог, хөрөнгө, орлогыг өөрийн эзэмшилд авч хамтран ашигладаг, хадгалдаг, нуудаг, халхавч болдог этгээдүүдийн энэхүү үйлдлийг таслан зогсоох юм.

11.Нийтийн албан тушаалтны албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа төрд болон бусдад хохирол учруулдаг зарим үйлдлийг (тухайлбал, албан үүрэгтээ хайнга хандах гэх мэт) Авлигын гэмт хэргийн төрөлд нэмж тусгаснаар төрөөс иргэн, хуулийн этгээдэд учруулах гэм хороос хамгаалахад түлхэц болно. Улмаар нийтийн албан тушаалтан хариуцлагатайгаар, шударгаар, бусдад хохирол учруулахгүйгээр албаны чиг үүргийг хэрэгжүүлэх баталгааг иргэд, олон нийтийн өмнө бүрдүүлнэ.

12.Авлигын зарим гэмт хэрэг нь цаг хугацааны хувьд оройтож илрэх мөн үйлдэгдсэн цаг хугацааг хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн байдлаар тогтоолгох магадлал өндөртэй байдаг ба авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг онцгойлон нэмэгдүүлж тусгасанаар авлигын гэмт хэрэгт холбогдож, буруутай

этгээдүүдэд зохих ял шийтгэл оноохгүй өнгөрөөх, гэмт хэргийг нь шийдэлгүй удаашруулах, улмаар улсад учирсан хохирлыг төлүүлэхгүй байх, авлигаар үүсгэсэн, олсон хөрөнгө, орлогыг хураахгүй байх явдлыг арилгахад гол түшиц болох юм.

13.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектийг нэмэгдүүлэх ба мөнгө угаах гэмт хэргийн шинж хийдэлгүй, тодорхой болно.

Тухайлбал, Нийтийн албан тушаалтны “төлөөний хүн” хууль ёсны өөрийн орлогоосоо их хэмжээгээр давсан хөрөнгө, орлого нь хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд Эрүүгийн хариуцлага ногдуулах нь авлигын гэмт хэргийн эсрэг бас нэг томоохон бодлого болох юм.

14.Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах харьяаллыг нэмэгдүүлж, мөрдөн шалгах байгууллагад Цагдаагийн байгууллагыг нэмж тусгана. Ингэснээр Цагдаагийн байгууллага Авлигатай тэмцэх газрын ачааллаас хуваалцаж, авлигын эсрэг хүч нэмэгдэх юм.

15.Төрийн аудитын байгууллагын шийдвэрийн биелэлт, нийтийн албан хаагчийн хууль бус ажиллагааны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин дутмаг, тогтолцоог хангалттай бүрдүүлээгүй, авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах хуульгүй байгаа асуудлыг шийдвэрлэж тус асуудлаар эрх зүйн тодорхой зохицуулалттай болно.

16.Авлигаас ангижирсан улс болох зорилтдоо хүрэх, мөн олон улс дахь авлигын индексийн үзүүлэлтэд сайнаар нөлөөлнө гэж үзэж байна.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай анхдагч хуулийн төсөл, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---oo---